



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/чб

Улаанбаатар хот

Барьцаа төлбөр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монгол хьюндай автомотив" ХХК 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан үйлчилгээний зориулалт бүхий машин техник нийлүүлэх ХСОАБХЗГ/20200301 дугаартай гэрээг хэрэгжүүлж дууссан тул чанарын баталгааны 5 хувьтай тэнцэх үнийн дүн болох 8,990,000 (Найман сая есөн зуун ерэн мянга) төгрөгийг нийлүүлэгчид олгохыг агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-г даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ